

## ЮАН УЛСЫН ҮЕИЙН ХАРХОРУМ ДАХЬ ХҮНСНИЙ ХАНГАЛТ НӨӨЦИЙН ТУХАЙ

*Мацуда Коичи\**

### 1. Хархорум руу чиглэсэн бараа материалыг урсгал өсөн нэмэгдсэн нь

Монголын Эзэнт гүрний анхны нийслэл Хархорум хот нь Хубилай хаан Жунду-г нийслэл (өөр нэр нь Хаан балгасан хожим түүний хажууд шинэ нийслэл Дайду хот байгуулагдсан. Одоогийн Бээжин) болгосноос хойш их гүрний нийслэл байхаа больсон юм. Гэвч XIII зууны сүүлчийн хагасаас хязгаар нутгийн нөхцөл байдлын элдэв өөрчлөлтөөс шалтгаалан дахин умардын хязгаар нутгийн гол хотын үүрэг гүйцэтгэх болсон юм.

1267 онд Монголын өндөрлөг Зүүн гарын хотгорын нутгуудад Жирх ноён зэрэг монгол язгууртнууд Юан улсын дотор бослого гаргаж байжээ. Бослогчид баруун Монгол дахь хүчнүүд, Хайдутай нийлж Юан гүрний баруун хойд хязгаарт түшүүртэй байдлыг бий болгосоор байлаа. Энэ нөхцөл байдлын улмаас Хархорум нь цэрэг стратегийн тэргүүн шугамын захиран зохицуулах түшиц газар болж, Хархорумаас баруун тийш байнга суулгасан Юан гүрний цэрэгт хоол хүнсний хангалтыг хийх болсон юм.

### 2. Хархорумд хоол хүнс бэлтгэн хангах 3 арга болон хүнсний хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж байсан нь

Монголын тал нутагт хоол хүнс бэлтгэн хангах гурван арга байжээ. 1). тухайн нутагт газар тариаланг (цэргийн тариалангийн аж ахуй) эрхлэн өргөжүүлэх, 2). засгийн газраас хариуцан умард Хятадын нутгаас хоол хүнс хүргэх, 3). Засгийн газар нутгийн худалдаачдаас хоол хүнс худалдан авах арга байжээ.

Бослого хөдөлгөөний эхний үе, өөрөөр хэлбэл, 1277 оны үеэс засгийн газраас хариуцаж хоол хүнс тээвэрлэн хүргүүлж, мөн цэргийн тариалангийн аж ахуйг эрхлэж байсан бөгөөд харин засгийн газар орон нутгаас хүнс хоол худалдаж авах ажил 1281-1286 оны үеэс хэрэгжиж

\* Мацуда Коичи - Япон улс. Осакагийн Олон Улсын Их сургуулийн профессор. Монголч эрдэмтэн, Монголын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хүндэт доктор.

эхэлжээ. Түүнчлэн Шанду, Инчан зэрэг Өвөр Монголын тал нутаг дахь гол гол хотуудад засгийн газраас хариуцан хүнс хоол тээвэрлэхийн оронд худалдаачид иргэд хариуцан тээвэрлэн хүргэх явдал ч байсан ажээ. Тухайн үед тээвэрлэн хүргэж байсан хүнсний хэмжээ нь 6 мянгаас 30 мянган коку (1 коку = 180 литр) орчим, тухайн орон нутгаас худалдан бэлтгэж байсан хоол хүнсний хэмжээ мөнгөн дүнгээрээ 20 мянган жёо (1281 он), хэмжээний хувьд 10 мянган коку (1288 онд)-д хүрч байлаа. Цэргийн тариалангийн аж ахуйн талаар, 1278 онд байгуулагдсан Өвөрхангай аймгийн Хайрхандулааны Хөгшин тээлийн балгас, Хархорум зэрэг хэд хэдэн газраас мэдэж болно. Тухайн үеийн үйлдвэрлэлийн хүчин чадлаас үзэхэд 2 хүн тариа тарихад 10 хүний хүнснийг бэлтгэж нөөцлөх боломжтой байлаа.

Гэвч тухайн шатанд Хархорум хавийн нутагт дээр өгүүлсэн хэлбэрийг бүгдийг нийлүүлээд бодоход ч тийм их хэмжээний хоол хүнс бэлтгэн нийлүүлэх боломж байгаагүй гэдэг нь тодорхой юм. 1284-1291 оны хооронд Хайдугийн талаас 700 мянга гаруй цэрэг Юан гүрэнд бууж өгч нийлсэн нь ихэнхдээ Датунгийн хавьд сууж байсан гэдэг нь нэгэнт тодорхой болсон. Датун нь Хятад газраас Монголын тал нутаг руу хүнс хоол тээвэрлэн нийлүүлэх хамгийн том бааз газар байсан болохоор хүнс тэжээлийн хангалт нийлүүлэлт дулимаг монголын бууж өгсөн цэргүүд энэ нутагт дүрвэн ирж суурьшиж байсан бололтой.

Хубилайгаас хойш Төмөр хааны үед 1297 онд Юан гүрний засаг захиргаа Хархорумд байнга сууж байсан цэрэгт зориулан ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө гарган нийлүүлж байсан тухай тэмдэглэл энд тэнд тааралддаг. Түрүүчийн жил 1296 онд Юан гүрнийг эсэргүүцээр ирсэн ноёд язгууртны зарим нь харьяат ардын хамт Юан гүрэнд бууж өгсөн юм. Тэдгээр хүн ам суурьшиж байсан Алтайн нуруунаас Хархорум хүртэлх өргөн газар нутагт Юан гүрний засаг захиргаа халамж анхаарал үзүүлэх хэрэгтэй болжээ. Юан гүрний засаг захиргаа тэдгээр ард иргэдэд халамж анхаарал үзүүлж, тэдний дэмжлэгийг хүлээсний үндсэн дээр Юан гүрний эсрэг тэмцээр ирсэн Хайдугийн талаар явуулж буй бодлогодоо ашиглахыг зорьж байв. Хархорумын орчинд байсан цэрэгт ихээхэн хэмжээний бэлэн мөнгө гарган нийлүүлж байсан нь тийнхүү хязгаар нутгийн цэргийн хүчин чадлыг бэхжүүлэх хүрээнд явагдаж байсан улс төрийн бодлого юм хэмээн үзэх үндэстэй.

Мөн Юан гүрний засаг захиргаа Хархорумд архи үйлдвэрлэхийг хориглож, хүнсний хэрэгцээнд зориулах будааг бэлтгэн нөөцлөх тусгай бодлого хэрэгжүүлэх (1299 он), цэргийн тариалангийн аж ахуйг эмхлэн нэгтгэх (1299 он), цэргийн хүнс тэжээл тээвэрлэлтийн

байдалд шалгалт хийх (1300 он), цэргийн тариалангийн аж ахуй эрхлэлтийн байдалд шалгалт хийх (1301 он), санхүү эрхлэсэн түшмэдийг яаралтай илгээж 80 мянган жёо будаа худалдан авах (1301 он) зэрэг дэс дараалсан арга хэмжээг авч байв.

Удаа дараагийн эдгээр арга хэмжээ нь бууж өгч дагаар орогсдыг оролцуулаад тооны хувьд ихээр өсч ирсэн Хархорум хавийн цэргийн хүчин чадлыг хэвээр барьж байхын тулд шаардагдах хүнс тэжээлийн нөөцийг хадгалж байх талаар тодорхой бодлого хэрэгжүүлж байсныг гэрчилж байна.

### 3. Их хэмжээгээр тээвэрлэж байсан цаг үе

1302 он гэхэд Хархорумд хүнсний зүйл бэлтгэн нөөцлөхийн тулд худалдаачдаар тээвэрлүүлэх, цэргийн тариалангийн аж ахуйг бэхжүүлэх, хүнсний зүйл бэлтгэн нийлүүлэхэд дутагдах зардлын асуудлыг шийдвэрлэхийн тулд давсны талон (давс олборлох газраас худалдан авч болох давсны үнийн дүнг тэмдэглэсэн талон)-оор худалдаачдад төлбөрийг хийх, мөн Датунгаас Хархорум хүртэл 4000 ли (1 ли = 0,5 км) зайд жилд 10 сарын турш 250 мянган коку ачаа тээвэрлэх систем бий болгох зэрэг санал засаг захиргааны шугамаар тавигдаж байв.

Энэ үйл явдлын дараа 1303 онд Хархорумд хувийн худалдаачдын тээвэрлэн авчирсан цагаан будааны тухайд 300 мянган коку будааг цэргийн хүнсэнд худалдан авахаар тооцоолж, үнэхээр худалдаачид ч ийм хэмжээний будааг тээвэрлэн хүргэсэн тухай мэдээ тэмдэглэгдэн үлджээ. Мөн Хархорумийн хавь нутагт архи үйлдвэрлэхийг хориглох бодлого хэрэгжүүлж (хойтон жил нь хориог цуцалсан) байсан, Хархорумаас хязгаар нутаг хүртэл ачаа тээвэрлэх тогтолцоог бий болгосон, бууж өгсөн 1 сая хүн амд хүнс бэлтгэн нийлүүлэх ажил урагштай бүтсэн зэрэг тэмдэглэл ч үлдэж хоцорчээ.

Хойд талын бүс нутгаас баруун хязгаарыг хамарсан өргөн уудам нутагт хоол хүнсийг тасралтгүй ханган нийлүүлж байх шаардлагаас Юан гүрний засаг захиргааны 10 дахь байгууллага бий болох бодит хэрэгцээ урган гарч, 1307 онд Хархорумд “Давааны арын муж”-ийг байгуулжээ. 1307-1309 оны хооронд Умард Монголын тал нутгийн цэргийн хэрэглээний аж ахуйд тариалсан ургашын хэмжээ 90 мянгаас 200 мянган коку байсан хэмээн тэмдэглэгдсэн байна. 1314 он хүртэл жил бүр хэдэн арван мянган коку хүнс тариаг Датунд суух санхүүгийн түшмэд хариуцан тээвэрлүүлдэг байв.

1276 оноос Хятадын төв хэсэг (Хөх мөрний сав газар)-ээс Дайдуй


(одоогийн Бээжин) руу хүнс хоол тээвэрлэх ажил нэгэнт эхлээд байв. Эхний үед суваг татаж түүнийгээ ашиглаж хүнс хоол тээвэрлэж байсан бөгөөд 1282 онд далайгаар тээвэрлэж эхлэн, түүнээс хойш удалгүй зөвхөн далайн тээвэр хэрэглэх болжээ. Ингэж далайгаар тээвэрлэсэн хүнс тэжээл 1309 оны үеэс нийслэл Дайду-гийн агуулахын халгалах хүчин чадлаас давж эхэлжээ. (графикаас үзнэ үү) 1311 онд Шанду (Юан гүрний үеийн зуны нийслэл)-гаас ачуулж байсан цагаан будааны хэмжээ жилдээ 300-400 мянган коку-д хүрч байв. (“Дай гэн соокоо ки” Их Юан улсын агуулахын тухай тэмдэглэл” х.28) Дайду-гийн агуулахын багтаамжийн хүчин чадлаас давсан цагаан будаа хаашаа явж байв аа гэвэл Шанду болон говь цөлийг давж Хархорум хүртэл тээвэрлэн тэнд зарцуулж байсан бололтой. Тийнхүү тээвэрлэж байсан цагаан будааны хэмжээг ч барагцаалан тооцоолж болохоор байна.

Тухайн үед Хархорумд 1316 онд 3-р сард цагаан будааг Шанду болон хойд талын бусад хотоос тээвэрлэн авчирсан худалдаачдаас 1 коку тутмыг 500 сэнээр, нэлээд өндөр үнээр (1309-1328 оны үед хойд Хятадал цагаан будааны үнэ 150-272 сэн) худалдан авч, хугацаанаас хожимдсон сар тутамд үнийг 50 сэнээр буулгаж авах арга хэмжээг авч байв. 3 жилд хэрэглэх нөөцийг бэлтгэж авсан хэмээн тэмдэглэснээс үзвэл дээр өгүүлсэнчлэн 200-230 мянган коку цагаан будаа худалдаачдын гараар дамжин Хархорум хүрдэг байжээ. 1316-1319 оны хооронд засгийн газар Хархорумд 200-230 мянган коку хүнсний зүйлс худалдан авч байсан тухай тэмдэглэл үлдсэн нь бий. Хархорумын Эрдэнэ зуу хийдэд байгаа “Давааны арын мужийн баруун гарын чинсангийн яаманд хүнс хүлээж авсан тэмдэглэл” хэмээх бичигт хөшөөнд 1347 оны үед засгийн газар худалдаачдаас 150 мянга орчим коку цагаан будаа худалдан авсан тухай тэмдэглэл байна.


Ийнхүү хувийн худалдаачид умард Хятадын нутгаас Монголын тал хээр хүртэл цагаан будааг тээвэрлэж байсан нь худалдан авах үнийг засгийн газраас зориуд өндөр байлгах бодлого баримталсан, далайн тээвэр хөгжиж ирснээр умард Хятад дахь цагаан будааны эрэлтээс нийлүүдэлтийн хэмжээ давж, гадагш тээвэрлэх боломжийг бүрдүүлсэн зэрэг нөхцөлтэй холбоотой юм.

Юан гүрний үед Монгол нутагт байсан цэргийн хүнс хоолны хангалт нөөцлөлтийн асуудлыг тухайн нутагт хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэлийг өсгөхийн зэрэгцээ засгийн газрын нарийн зохицуулалтын үндсэн дээр умард Хятадын нутгаас явуулах худалдаа арилжааг идэвхжүүлэх бодлоготой уялдуулан шийдвэрлэж байсан нь тодорхой юм.

Дайду дахь будааны агуулахын багтаамж болон далайн тээврээр зөөж байсан будааны хэмжээ /1260-1329/



Европын тооллоор



DARDESS, J.W. 1973 From Mongol Empire to Yuan Dynasty: Changing Forms of Imperial Rule in Mongolia and Central Asia. Monumenta Serica 30 (1972-1973), pp. 117-165

ЧУЛУУНЫ ДАЛАЙ. Монголия в XIII веке, Москва, 1983

PS: Энэхүү өгүүлийг академич Ч.Далайн 70 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд зориулан 2000 оны 11-р сард тус сэтгүүлийн редакцид ирүүлсэн болно.

Япон хэлнээс орчуулсан Б.Сэржав. (Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор)